

ХАНБОГД СУМЫН МАЛЧДЫН ТӨЛӨӨЛӨЛ БОЛОН ОЮУ ТОЛГОЙ КОМПАНИЙН ХЭЛЦЛИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Ханбогд сум

Их булаг

2014 оны 9-р сарын 30-ны өдөр

Та бүхэнд САО-н оролцоотой маргааныг шийдвэрлэх Малчдын төлөөлөгчид болон Оюу Толгой ХХК-ийн хамтарсан уулзалтаар тохирсон асуудлын тухай мэдээлдэг билээ. Энэ удаад 9-р сарын 30-ны өдөр хийгдсэн уулзалтын тойм мэдээг хүргүүлж байна. Уулзалтыг уламжлалт ёсоор Олон улсын санхүүгийн корпорацийн омбудсмэн (САО)-ий газрын зуучлагч чиглүүлж, Оюу Толгой Хяналт ТТБ малчдын зөвлөхөөр оролцов.

Түрүүчийн уулзалтаас хойш хоёр талын хийхээр тохирсон ажлуудын хэрэгжилтийг талууд танилцуулсан.

Энэ удаагийн уулзалтаар хэлэлцэж тохирсон ажлууд:

- Малчдын төлөөлөгчдийн 5-р сард гаргасан хүсэлтийн дагуу Оюу Толгой уурхайн талбайгаас 20 км радиус дотор байгаа худаг нь үсгүй болсон Ханбогд сумын малчдыг уурхайгаас зөөврийн усаар хангаж байгаа явцыг хоёр тал хянан үзэж өвлийн улиралд үргэлжлүүлэх боломжийг ойрын хугацаанд хамтран судлах. Цаашид малчдад тулгамдаж буй усны асуудлыг шийдэх урт хугацааны шийдлийг хайх.
- Иргэдийн нийтийн хурлаас эрэмблэгдэн гарч байгаа худаг сэргээн засварлах жагсаалтын дагуу Оюу Толгойн мэргэжлийн баг ажиллаж, хамгийн хүнд байдалтай байгаа худгуудыг тогтоон нэн түрүүнд авч үзэх.
- Оюу Толгой компаниас Ханбогд суманд шинээр худаг гаргах, хуучин худаг сэргээн засварлах компанийг сонгон шалгаруулах асуудал удааширсантай холбогдуулан тус компанийн Хангамж, худалдан авалтын багийг дараагийн уулзалтад оролцуулж мэдээлэл авах.
- Малчидын төлөөлөгчид Оюу Толгой уурхайн талбайд орж үйлдвэрлэлийн циклтэй танилцах, кемпийн удирдлагатай уулзах хоёр өдрийн ажлыг 11-р сарын эхээр зохион байгуулах. Энэ үеэр дараагийн уулзалтыг зохион байгуулах боломжтой хэмээн үзлээ.
- Олон Талт Мэргэжлийн Шинжээчийн Багийн Ажлын удирдамжийг эцэслэн тохирч бэлэн болгох эдгээр болно.

Ханбогд сумын Малчдын төлөөлөгчид,

Оюу Толгой ХХК